

АГУУЛГА

1. Хамрах хүрээ.....	2
2. Баталгаажуулалтын үйл ажиллагаа ба ашиглах хэмжих хэрэгслүүд.....	6
3. Баталгаажуулалтын нөхцөл ба бэлтгэл ажил.....	7
4. Баталгаажуулалтыг гүйцэтгэх ба хэмжлийн үр дүнг боловсруулах.....	7
5. Баталгаажуулалтын үр дүнг тайлагнах.....	9

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 17.040.30

Зам төмөр хэмжигч. Баталгаажуулалтын арга хэрэгсэл	MNS:2022
Track measurer. Method of verification	

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2022 оны ... дугаар сарын ...-ны өдрийн ... дугаар тогтоолоор батлав.

Энэхүү стандарт нь 2022 оны оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн хүчинтэй.

1. Хамрах хүрээ

Энэхүү баталгаажуулалтын арга хэрэгсэл нь төмөр зам хэмжигч загварт хамаарах бөгөөд ашиглалтын өмнөх болон ашиглалтын үеийн анхдагч, ээлжит баталгаажуулалтын аргачлалыг тогтооно.

Баталгаажуулалт хоорондын хугацаа 6 сараас ихгүй байна.

2. Баталгаажуулалтын үйл ажиллагаа ба ашиглах хэмжих хэрэгслүүд

2.1 Баталгаажуулалтын явцад хүснэгтэд заасан хэмжих хэрэгслүүдийг ашиглаж, бүх үйл ажиллагааг гүйцэтгэсэн байна.

Хүснэгт 1.

Үйл ажиллагааны дараалал	Зүйлийн дугаар	Хэмжих хэрэгслүүд ба тэдгээрийн үндсэн үзүүлэлтүүд
1	2	3
1.Гадна үзлэг	5.1	Томруулдаг шил ЛП-1-10 ГОСТ25706-83
2.Эд ангийн харилцан үйлчлэл	5.2	
3. Хэмжлийн хязгаарын шалгалт - царигийн өргөн - шилжих тахирын хэмжээ - зүрхэвчний хувилын өргөн - хаших зам төмөр болон зүрхэвчний ажлын ирмэг хоорондын зай - рельсийн өндрийн зөрүү	5.3	Штангенциркуль ШЦ-Ш 500-1600-0,1-1, MNS ISO 13385-1:2015 Штангенциркуль ШЦ-Ш 500-1600-0,1-1, MNS ISO 13385-1:2015 Замын загвар баталгаажуулах стэнд ТУ32 ЦП 317-73 (төгсгөлт уртын хэмжүүр 2 анги MNS ISO 3650 и шалгалтын хавтан КТ 3 ГОСТ 10905-86)
4. Хэмжлийн алдааг тодорхойлох - царигийн өргөн - шилжих тахирын хэмжээ	5.3	Штангенциркуль ШЦ-Ш 500-1600-0,1-1, MNS ISO 13385-1:2015

<ul style="list-style-type: none"> - зүрхэвчний хувилын өргөн - хаших зам төмөр болон зүрхэвчний ажлын ирмэг хоорондын зай - рельсийн өндрийн зөрүү 		Штангенциркуль ШЦ-Ш 500-1600-0,1-1, MNS ISO 13385-1:2015
--	--	--

2.2 Шаардагдах нарийвчлал хангасан тоон заалттай хэмжих хэрэгслийг ашиглаж болно.

3. Аюулгүй ажиллагааны шаардлага

3.1 Баталгаажуулалтын үйл ажиллагааны үед дараахь зүйлийг анхаарна. Үүнд:

- Биеийн ил хэсэгт тосолгооны тос ба бензин зэргийг хүргэхгүй байх;
- Загварыг унагах ба түүнийг стэндэд суурилуулах, эргүүлэх явцад ажилтан бэртэлд өртөхөөс сэргийлэх.

4. Баталгаажуулалтын нөхцөл ба бэлтгэл

4.1 Баталгаажуулалт гүйцэтгэх үед дараах нөхцлүүдийг баримтлан ажиллана. Үүнд:

- Тасалгааны хэм 20 ± 5 °C;
- Тасалгааны хэмийн 1 цагийн хугацааны өөрчлөлт $0,5$ °C ихгүй байх;
- Агаарын даралт $(101,08 \pm 7,98)$ кПа эсвэл (760 ± 60) м.у.б.;
- Агаарын харьцангуй чийгшилт (65 ± 15) %.

4.2 Баталгаажуулалтын өмнө суурийн хэмжлийн гадаргуугийн бохирдлыг ГОСТ 1012-2013 бензинээр цэвэрлэнэ.

4.3 Баталгаажуулалтын өмнө загварыг 3 цагаас доошгүй хугацаанд ажлын орчинд байлгана.

5. Баталгаажуулалтыг гүйцэтгэх ба хэмжлийн үр дүнг боловсруулах

5.1 Гадна үзлэг

5.1.1 Гадна үзлэгийн үед хийх шалгалтууд:

5.1.1.1 Иж бүрдэл нь үйлдвэрлэлийн норматив техникийн баримт бичгийн шаардлагад нийцсэн эсэх;

5.1.1.2 Загварын хэмжлийн гадаргуу дээр зэв, идэгдэлт, өө ургацаг, механик гэмтэл байхгүй байх;

5.1.1.3 Хамгаалалтын бүрхүүлийн чанар (зөвхөн шинэ загвар үйлдвэрээс гарахад)

5.1.1.4 Хуваарийн тэмдэглэгээний чанар (томруулагч шил ашиглах)
Тэмдэглэгээ нь тасалдаагүй жигд, урт болон өргөний хэмжээ тэнцүү байна.

5.1.2 Засвараас гарсан болон ашиглалтад байгаа загварын ашиглалтын чанарт нөлөөлөх гэмтэл байх ёсгүй.

5.2 Эд ангийн харилцан үйлчлэл

5.2.1 Татах хөшүүрэг дээр гараар дарахад хөдөлгөөнт тулгуур загварын тэнхлэгийн дагуу гацалтгүй жигд шилжих ба харин энэ үед ПК ординатын заагч хуваарийн дагуу 1430 мм -ээс 1480 мм хязгаарт хөдөлнө.

5.2.2 Түвшний хуваарь бүхий дискийг цагийн зүүний дагуу болон эсрэг талруу тэг заалтаас ± 160 мм хүртэл гараар зөөлөн эргүүлнэ.

5.2.3 Дундын хөдөлгөөнт тулгуур нь шугамын дагуу хэмжлийн нийт хязгаарт гараар чөлөөтэй шилжигдэнэ. (40 мм-ээс 1400 мм хүртэл)

5.3 Хэмжлийн хязгаарын шалгалт

5.3.1 Царигийн өргөний хэмжлийн хязгаар, шилжих тахирын хэмжээс, зүрхэвчний хувилын өргөн, хаших зам төмөр болон зүрхэвчийн ажлын ирмэгүүдийн хоорондох зай, түүнчлэн алдааг энэ хэмжлийн хязгаарт хэвтээ байрлалд штангенциркулээр шалгана.

Загварын тухайн хэмжлийн гадаргуунуудын хоорондын зайг дараах хэмжлийн хязгааруудад тохируулна.

- Царигийн өргөн (1510, 1520, 1530, 1540 ба 1550) мм;
- Шилжих тахирын хэмжээ (40, 500, 1400, 1430, 1460 ба 1480) мм;
- Зүрхэвчний хувилын өргөн (40, 190 ба 320) мм;
- Хаших зам төмөр болон зүрхэвчийн ажлын ирмэгүүдийн хоорондын зай (1470, 1485 ба 1500) мм.

Үүний дараа нь эдгээр зайг хяналтын загвар ашиглан цэг тус бүрд 3-аас доошгүй хэмжинэ. Шалгалтын цэг бүр дэх хэмжлийн зайн хязгаарт алдаа нь $\pm 1,0$ хязгаарт байвал хэмжлийн үр дүнг эерэгээр тооцно.

Нэг зам төмөр, нөгөөгөөс өндөр байгаа эсэхийг өндөрийн зөрүү хэмжих стендийн тусламжтай 0, ± 80 , ± 160 мм шатлалд тодорхойлно. Стендийн хөшүүргийн тулгуур дээр загварыг суурилуулж, харин хөшүүргийг тулгуурт хөлний 0 хөлөнд суурилуулна. Үүний дараа загварын өндрийн зөрүүний хуваарийн дискийг, тэгш усны бөмбөлгийг шингэний дундын зурааснуудын хооронд иртэл эргүүлэх ба дараа нь риск заагчийн заалтыг авна. Хөлтэй тулгуурын «80» «160» шатлалд 3-аас доошгүй хэмжилт хийнэ. Өндрийн зөрүүний «80» «160» шатлалд заалтыг авахын тулд, «80» «160» шатлалд байгаа, хөшүүрэг дээрх загварыг 180 хэм эргүүлэхдээ түүний хөдөлгөөнгүй тулгуур стендийн хөшүүргийн баруун тулгуур дээр байрлахаар эргүүлнэ.

Өндрийн зөрүүний хэмжлийн алдааг 5 цэг тус бүрийн заалтын арифметик дунджаар тодорхойлох ба цэг тус бүр дээрх алдаа $\pm 1,0$ мм байна.

6. Баталгаажуулалтын үр дүнг тайлагнах

- 6.1** Зам хэмжигч загварын баталгаажуулалтын эерэг үр дүнг үндэслэн гэрчилгээ олгоно. Баталгаажуулалтын гэрчилгээг гарын үсэг, тамга, тэмдгээр баримтжуулна.
- 6.2** Баталгаажуулалтын үр дүн энэхүү аргачлалд заасан аль нэг нөхцлийн шаардлагыг хангаагүй тохиолдолд төмөр зам хэмжигч загварыг ашиглахыг хориглосон мэдэгдэл олгох ба мэдэгдэлд тухайн шалтгааныг тодорхой бичнэ. Мэдэгдлийг гарын үсэг, тамга, тэмдгээр баримтжуулна.